

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2023 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 13

Арвайхээр

Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааг үнэлж дүгнэх, үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн 6 асуулга бүхий судалгааг цаасан хэлбэрээр нийт 163 иргэнээс авсан.

Асуулга тус бүрийн нэгтгэлийг дараах байдлаар харуулав.

1. Тухайн байгууллага, аж ахуйн нэгжид хийгдсэн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хэр чанартай хэрэглэгчдэд хүртээмжтэй, үнэн зөв шударга хийгдсэн бэ?

79,8 хувь нь хангалттай сайн, 16,6 хувь нь дунд түвшинд.

2. Хяналт шалгалт, дотоод аудитын үр дүнг хэрхэн үнэлж байна вэ?

60,7 хувь нь үр дүн маш сайн, 27,6 хувь нь үр дүн дунд түвшинд байна.

3. Өмнөх санхүүгийн хяналт шалгалтын үр дүнд танай байгууллагад ямар өөрчлөлт гарсан бэ?

22,1 хувь нь эерэг өөрчлөлтүүд маш их гарсан, 16 хувь нь өөрчлөлт огт гараагүй, 16 хувь нь илэрсэн санхүүгийн зөрчлүүд арилж байгаа, 38 хувь нь мэдэхгүй,

4. Танай байгууллагын дотоод хяналтын нэгж нь байгууллагынхаа санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж чадаж байгаа юу?

27,6 хувь нь огт хийхгүй байгаа, 44,8 хувь нь дунд түвшинд хийж байгаа, 15,3 хувь нь сайн хийгдэж байгаа, 10,4 хувь нь санхүүгийн мэдлэггүйгээс хийж чадахгүй байгаа,

5. Танай байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа ил тод нээлттэй байж чадаж байгаа юу?

34,4 хувь нь санхүүгийн бүх мэдээлэл ил тод байгаа, 18,4 хувь нь зарим мэдээллийг бидэнд мэдээлдэггүй, 40,5 хувь нь санхүүгийн үйл ажиллагааг ил тод болгож чадаагүй,

6. Авлигаас ангид байж хяналт шалгалт нээлттэй, ил тод явагдаж чадсан уу?
1,2 хувь нь тийм гэж тус тус хариулсан.

Санал асуулгын нэгдсэн дүгнэлт:

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд ил тод нээлттэй байдлаар явагдаж, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, зөвлөгөө өгөх байдал, санхүүгийн хяналт шалгалтын үр дүн хангалттай, харилцаа хандлага сайн байгааг илэрхийлж байна. Үнэлгээгээр тухайн байгууллагуудын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, сайжруулах, хөгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Үнэлгээнд хамрагдсан хэрэглэгчдээс сургалт авах, хяналт шалгалтыг 1-2 жил тутамд тогтмол хийх, хяналт шалгалтыг ойр ойр хийснээр зөрчил дутагдал арилах, заавар зөвлөмжийг авч ажилласнаар санхүүгийн үйл ажиллагаа сайжирна гэсэн хүсэлтүүд ирүүлсэн.

ХЯНАСАН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГА

М.ЭРДЭНЭЧУЛУУН

ТАЙЛАН ГАРГАСАН:
АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Д.ЧУЛУУНБАДРАХ